


2022 оны I улиралд Батлан хамгаалах салбарын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлын тухай

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалыг тус тус мөрдлөг болгон салбарын хэмжээнд цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих шийдвэр гаргуулан хуулийн хугацаанд нь хариуг өгч ажиллалаа.

Нэг. Батлан хамгаалах салбарын хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Батлан хамгаалах салбарын хэмжээнд нийт 2590 өргөдөл, гомдол ирүүлснээс 2330 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилт 89,9 хувьтай байна. Энэ оны I улиралд багтаж шийдэгдээгүй, шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа хугацаа болоогүй 75 өргөдөл байгаа бөгөөд харьяа байгууллага, тухайн асуудал хариуцсан албан тушаалтанд 185 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шилжүүлж, холбогдох арга хэмжээг авхуулсан байна.



Албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг дараах 4 сувгаар хүлээн авч, ажилласан. Үүнд:

1. БХЯ-ны “Иргэд хүлээн авах байр”-нд биечлэн;
2. 458929 дугаарын утсаар;
3. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс цахим хэлбэрээр;

4. БХЯ-ны цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлсэн байна.

2022 оны I улиралд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан сувгуудаар нь ангилбал:

- ❖ 2491 буюу 96,1 хувь нь бичгээр;
- ❖ 3 буюу 0,11 хувь нь ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс;
- ❖ 3 буюу 0,11 хувь нь цахимаар;
- ❖ 93 буюу 3,5 хувь нь утсаар тус тус ирүүлжээ.

2022 оны I улиралд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг харьяалах байгууллага, төрлөөр нь ангилан үзүүлбэл:

Д/д	Байгууллагын нэр	БХ бодлого, ЗХ-ний үйл ажиллагааны талаарх гомдол, санал,	Ажлын байртай холбоотой	Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцах	ЭДА-ны сонгон шалгаруулалттай холбоотой	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэхийг хүссэн	Талархал	Бусад	Нийт
1	БХЯ	93	159	27	3	160	1	56	499
2	ЗХЖШ		245	21		426		364	1056
3	ХЗЦК		209	8		335		78	630
4	АЦК		8	7		33		357	405
Нийт		93	621	63	3	954	1	855	2590

Тус яаманд иргэд, цэргийн алба хаагчдаас ирсэн өргөдлүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдэж, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан шууд шийдвэрлэх боломжгүй удаан хугацаанд шийдвэрлэгдэх 185 өргөдлийг тус зааврын 3 дугаар зүйлийн 3.3.7 дахь заалтын дагуу нэр төрөл, агуулга, харилцагчийн шинжээр нь бүлэглэн, тус тусад нь дугаар өгч, бүртгэн хадгалж, шийдвэрлэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дэх хэсэгт заасан “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана” гэж заасны дагуу богино хугацаанд шийдэх боломжтой өргөдлийг хуулийн хугацааг хүлээхгүйгээр богино хугацаанд шийдвэрлэн иргэнд хариу өгч ажиллаж байна. Үүний үр дүнд Батлан хамгаалах салбарт ирсэн нийт өргөдлийн 37,6 хувийг 1-7 хоногт, 33,4 хувийг 8-14 хоногт, 15,5 хувийг 15-21 хоногт, 13,5 хувийг 22-30 хоногт тус тус шийдэж хариуг өгсөн бөгөөд хуулийн хугацаа хоцроож шийдсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын дийлэнх хувийг нийгмийн хамгааллын асуудалтай холбоотой өргөдөл эзэлж байгаа юм.

Нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдлийг судлан үзэхэд тодорхой хугацаа шаардсан, тухай бүрт нь шийдвэрлэхэд хүндрэлтэй /албан тушаалын орон сууц олгуулах, мөнгөн дэмжлэг хүссэн г.м/ өргөдлүүд байгаа бөгөөд эдгээрийг тусгайлан бүртгэж, дараалалд оруулах арга хэмжээг авч, хариуг хүргүүлэн ажиллаж байна.

Хоёр. Батлан хамгаалах яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах яамны удирдлагад хандаж иргэдээс 205 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 186 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 14 өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн өгсөн бөгөөд хэрэгжилт 90 хувьтай байна. 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 5 өргөдлийг судалж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг албан тушаалтнуудад хандаж гаргаснаар нь харуулбал:

- ✓ Батлан хамгаалахын сайдад 42 буюу 20,4 хувь;
- ✓ Батлан хамгаалахын дэд сайдад 2 буюу 0,9 хувь;
- ✓ Төрийн нарийн бичгийн даргад 47 буюу 22,9 хувь;
- ✓ Төрийн захиргааны удирдлагын газрын даргад 21 буюу 10,3 хувь;
- ✓ хаяглагдан ирсэн байна.
- ✓ Батлан хамгаалах яамны 1800-1144 тусгай дугаарт 93 буюу 45.2 хувь тус тус эзэлж байна.

Гурав. “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын **1800-1144** тусгай дугаарт иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн жинхэнэ алба хаагчидтай холбоотой бүхий л төрлийн санал, хүсэлт, мэдээллийг 24 цагаар тасралтгүй хүлээн авч байгаа бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар “Батлан хамгаалах-Иргэний хяналт” 1800-1144 тусгай дугаарт 93 дуудлага ирснийг хүлээн авч 100 хувь шийдвэрлэсэн.

Тусгай дугаарын дуудлага хүлээн авах бүртгэлийн өдөр бүр хянан 7 хоног бүр нэгтгэн Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчид танилцуулж ажилласан.

Дөрөв. Бусад байгууллагаас харьяаллын дагуу уламжлагдан ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, яамны харьяа байгууллагуудаас 2022 оны I улиралд нийт 5 өргөдөл, гомдол шилжин ирснийг судлан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгч ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсын Их Хурал 3 буюу 60 хувь;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар 1 буюу 20 хувь;
- БХЯ-ны харьяа байгууллага 1 буюу 20 хувийг тус тус эзэлж байгаа болно.

Тав. Өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг багасгах, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д заасны дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд нь хариуг өгөхөд анхаарал хандуулан ажиллаж байна.

Иргэд, албан тушаалтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг газар дээр нь болон богино хугацаанд шийдвэрлэх боломжтой бол ихэвчлэн утсаар мэдэгдэх эсвэл албан бичгээр хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд биечлэн уулзаж амаар хариуг нь аль болох түргэн шуурхай хүргэх хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Зургаа. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах
“11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн санал, хүсэлт,
гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2022 оны I улиралд Монгол Улсын Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс 3 гомдол, хүсэлт хуваарилагдан ирсэн байна. Тус төвөөс хуваарилагдаж ирүүлсэн гомдол, хүсэлтийг тухай бүрт нь хүлээн авч тодотгон, холбогдох арга хэмжээг авч, хариуг өгч ажилласан.

Мөн Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн тогтоосонд хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Долоо. Байлдаанд оролцсон ахмад дайчид,
тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмад дайчид, тэдгээрийн гэр бүлээс
ирүүлсэн хүсэлтийг судлан нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар:

Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Ардын болон гавьяат цолтон, Төрийн шагналт, Төрийн соёрхолт, Ахмад дайчин, Улсын ударник, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүдэд сар бүр нэмэгдэл олгодог.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар уг нэмэгдлийн санхүүжилтийг нийгмийн халамжийн сангаас хасч, тухайн ахмад настны шагнагдсан алдар цолны харьяалах салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцад тусган баталсны дагуу Батлан хамгаалах салбарын харьяаны 71 алдар цолтон, ахмад настнуудад нэмэгдэл мөнгөн дэмжлэгийг хуулийн дагуу сар бүр олгож байна.

2022 оны I улиралд 1939 оны Халхын голын дайн, 1940-1948 онд Улсын баруун хилд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад дайчин Далхын Лувсанренчин, Тангаагийн Бадарч, Чойжилын Лувсандорж, Гүрсэдийн Баарай, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Галсанцэрэнгийн Цэрэнлхам нь зуурдаар нас барсан тул тэдний ар гэрт нь буцалтгүй тусламж тус бүр 100,000 (нэг зуун мянга) төгрөг, нийт 500,000 (таван зуун мянга) төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон.

Батлан хамгаалахын яамны нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хүрээнд Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагаас өөрийн орон гэргүй, түрээсийн орон сууцанд амьдардаг, ар гэр нь гал түймэрт өртсөн болон нэн шаардлагатай байгаа гэр хүссэн нийт 30 алба хаагчдад иж бүрэн 5 ханатай гэрийг хүлээлгэн өгсөн.

Дүгнэлт:

2022 оны I улиралд Батлан хамгаалах салбарт алба хааж буй цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, зохих шийдвэрийг гаргуулан, хуулийн хугацаанд хариуг хурдан шуурхай өгөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн

дагуу зохион байгуулж Батлан хамгаалах яам, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтыг зохих түвшинд хангасан гэж үзэж байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

**2022 ОНЫ I УЛИРАЛД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ**

**НЭГ. БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ,
АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ,
БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА**

1.1.БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Хүснэгт №1.1

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь	
			Шийдвэрлэж, хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй		
1.1	БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА	Батлан хамгаалах яам	205	186	14		5	90.3
		Үндэсний батлан хамгаалахын их сургууль	59	40	12		7	88.1
		Цэргийн төв эмнэлэг	41	40			1	97.5
		Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга	54	53	1			98.1
		Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс	13	13				100
		Алдар спорт хороо	15	14	1			93.3
		Батлан хамгаалахын төв архив	10	10				100
		Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг	4	4				100
		Монгол цэргийн музей	3	3				100
		Соёмбо редакц	1	1				100
		Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ	2	2				100
		Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ	1	1				100
		Бөртэ ТӨААТҮГ	83	83				100
		Багабаян ТӨААТҮГ	8	8				100
ДҮН		499	458	28		13	97.1	

1.2. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА

Хүснэгт №1.2

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэрлэж, хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1.2	ЗХЖШ, ТХЦК, КАБЦК, БИЦУГ-ЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА	Зэвсэгт хүчний Жанжин штаб	10	10			100
		Тусгай хүчний цэргийн командлал	14	6	8		100
		Кибер аюулгүй байдлын цэргийн командлал	2		2		100
		Барилга, инженерийн цэргийн удирдах газар	4	4			100
		Зэвсэгт хүчний нэгдсэн лаборатори	8	8			100
		Зэвсэгт хүчний 011 дүгээр анги	20	20			100
		Зэвсэгт хүчний 013 дугаар анги	43	43			100
		Зэвсэгт хүчний 015 дугаар анги	16	16			100
		Зэвсэгт хүчний 017 дугаар анги	43	31	12		100
		Зэвсэгт хүчний 032 дугаар анги	50	50			100
		Зэвсэгт хүчний 084 дүгээр анги	28	26	2		100
		Зэвсэгт хүчний 089 дүгээр анги	70	70			100
		Зэвсэгт хүчний 010 дугаар анги	31	28	3		90
		Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	23	21	2		100
		Зэвсэгт хүчний 142 дугаар анги	10	10			100
		Зэвсэгт хүчний 150 дугаар анги	62	62			100
		Зэвсэгт хүчний 189 дүгээр анги	23	23			100
		Зэвсэгт хүчний 232 дугаар анги	37	35	2		100
		Зэвсэгт хүчний 284 дүгээр анги	4	4			100
		Зэвсэгт хүчний 310 дугаар анги	8	6	2		75
		Зэвсэгт хүчний 311 дүгээр анги	36	29	7		100
		Зэвсэгт хүчний 314 дүгээр анги	61	59		2	96.7
		Зэвсэгт хүчний 330 дугаар анги	78	75		3	96.1
		Зэвсэгт хүчний 331 дүгээр анги	178	163	15		100
		Зэвсэгт хүчний 334 дүгээр анги	37	37			100
		Зэвсэгт хүчний 338 дугаар анги	21	9	7		42.5
Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	57	57			100		
Зэвсэгт хүчний 340 дүгээр анги	25	22		3	88		
Зэвсэгт хүчний 341 дүгээр анги	0				0		
Зэвсэгт хүчний 342 дугаар анги	3	3			100		

		Зэвсэгт хүчний 345 дугаар анги	4	4			100
		Зэвсэгт хүчний 350 дугаар анги	50	50			100
Дүн			1056	981	62	13	99.6

1.3. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА

Хүснэгт №1.3

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь	
			Шийдвэрлэж, хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй		
1.3	ХЭЦК-ЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ	Хуурай замын цэргийн командлал	47	42	-		5	89.4
		Зэвсэгт хүчний 014 дүгээр анги	35	35	-		-	100
		Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл	61	61	-		-	100
		Зэвсэгт хүчний 119 дүгээр анги	30	27	3		-	100
		Зэвсэгт хүчний 120 дугаар анги	22	20	-		2	90%
		Зэвсэгт хүчний 123 дугаар анги	52	52	-		-	100
		Зэвсэгт хүчний 167 дугаар анги	39	32	7		-	100
		Зэвсэгт хүчний 186 дугаар анги	48	35	8		5	89.6
		Зэвсэгт хүчний 234 дүгээр анги	52	52	-		-	100
		Зэвсэгт хүчний 256 дугаар анги	55	54	1		-	100
		Зэвсэгт хүчний 326 дугаар анги	32	32			-	100
		Зэвсэгт хүчний 327 дугаар анги	109	105	4		-	100
		Зэвсэгт хүчний 336 дугаар анги	48	43	3		2	94
ДҮН		630	590	26		14	97.1	

1.4. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХАРЬЯА АНГИ, БАЙГУУЛЛАГА

Хүснэгт №1.4

Д/д	Байгууллагын нэр		Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
				Шийдвэрлэж, хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1.4	АЦК-ЫН ХАРЬЯА АНГИ	Агаарын цэргийн командлал	15	15	-	-	100	
		Зэвсэгт хүчний 065 дугаар анги	74	58	11	5	100	
		Зэвсэгт хүчний 303 дугаар анги	32	20	12	-	62.5	
		Зэвсэгт хүчний 325 дугаар анги	201	158	43	43	78.6	
		Зэвсэгт хүчний 337 дугаар анги	37	37	-	-	100	
		Зэвсэгт хүчний 353 дугаар анги	46	43	3	-	100	
ДҮН			405	331	69	48	81.7	

ХОЁР. БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГУУДАД 2022 ОНЫ I УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2.1.БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

№2.1

Д/д	Байгууллагын нэр		Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс				
				Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
2.1	БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА	Батлан хамгаалах яам	205	112		93		
		Үндэсний батлан хамгаалахын их сургууль	59	59				
		Цэргийн төв эмнэлэг	41	40				
		Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга	54	53				
		Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс	13	13				
		Алдар спорт хороо	15	14				
		Батлан хамгаалахын төв архив	10	10				
		Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг	4	4				
		Монгол цэргийн музей	3	3				
		Соёмбо редакц	1	1				
		Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ	2	2				
Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ	1	1						

	Бөртэ ТӨААТҮГ	83	83	1		2	
	Багабаян ТӨААТҮГ	8	8				
	ДҮН	499	403	1	93	2	

2.2. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА

Хүснэгт №2.2

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
2.2	ЗХЖШ, ТХЦК, КАБЦК, БИЦУГ-ЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА	Зэвсэгт хүчний Жанжин штаб	10	10			
		Тусгай хүчний цэргийн командлал	14	14			
		Кибер аюулгүй байдлын цэргийн командлал	2	2			
		Барилга, инженерийн цэргийн удирдах газар	4	4			
		Зэвсэгт хүчний нэгдсэн лаборатори	8	8			
		Зэвсэгт хүчний 011 дүгээр анги	20	20			
		Зэвсэгт хүчний 013 дугаар анги	43	43			
		Зэвсэгт хүчний 015 дугаар анги	16	16			
		Зэвсэгт хүчний 017 дугаар анги	43	43			
		Зэвсэгт хүчний 032 дугаар анги	50	50			
		Зэвсэгт хүчний 084 дүгээр анги	28	28			
		Зэвсэгт хүчний 089 дүгээр анги	70	70			
		Зэвсэгт хүчний 010 дугаар анги	31	31			
		Зэвсэгт хүчний 124 дүгээр анги	23	23			
		Зэвсэгт хүчний 142 дугаар анги	10	10			
		Зэвсэгт хүчний 150 дугаар анги	62	62			
		Зэвсэгт хүчний 189 дүгээр анги	23	23			
		Зэвсэгт хүчний 232 дугаар анги	37	37			
		Зэвсэгт хүчний 284 дүгээр анги	4	4			
		Зэвсэгт хүчний 310 дугаар анги	8	8			
		Зэвсэгт хүчний 311 дүгээр анги	36	36			
		Зэвсэгт хүчний 314 дүгээр анги	61	61			
		Зэвсэгт хүчний 330 дугаар анги	78	78			
Зэвсэгт хүчний 331 дүгээр анги	178	178					
Зэвсэгт хүчний 334 дүгээр анги	37	37					
Зэвсэгт хүчний 338 дугаар анги	21	21					
Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	57	57					
Зэвсэгт хүчний 340 дүгээр анги	25	25					

		Зэвсэгт хүчний 341 дүгээр анги	0	-				
		Зэвсэгт хүчний 342 дугаар анги	3	3				
		Зэвсэгт хүчний 345 дугаар анги	4	4				
		Зэвсэгт хүчний 350 дугаар анги	50	50				
		ДҮН	1056	1056				

2.3. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА

Хүснэгт №2.3

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс					
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад	
2.3	ХЭЦК-ЫН ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ	Хуурай замын цэргийн командлал	47	47			2	
		Зэвсэгт хүчний 014 дүгээр анги	35	35				
		Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл	61	61				
		Зэвсэгт хүчний 119 дүгээр анги	30	30				
		Зэвсэгт хүчний 120 дугаар анги	22	22				
		Зэвсэгт хүчний 123 дугаар анги	52	52				
		Зэвсэгт хүчний 167 дугаар анги	39	39				
		Зэвсэгт хүчний 186 дугаар анги	48	48				
		Зэвсэгт хүчний 234 дүгээр анги	52	52				
		Зэвсэгт хүчний 256 дугаар анги	55	55				
		Зэвсэгт хүчний 326 дугаар анги	32	32				
		Зэвсэгт хүчний 327 дугаар анги	109	109				
		Зэвсэгт хүчний 336 дугаар анги	48	48				
	ДҮН	630	630			2		

2.4. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ХАРЬЯА АНГИ, БАЙГУУЛЛАГА

Хүснэгт №2.4

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
2.4	АЦК-ЫН ХАРЬЯА АНГИ	Агаарын цэргийн командлал	15	15			
		Зэвсэгт хүчний 065 дугаар анги	74	74			
		Зэвсэгт хүчний 303 дугаар анги	32	32			
		Зэвсэгт хүчний 325 дугаар анги	201	201			
		Зэвсэгт хүчний 337 дугаар анги	37	37			
		Зэвсэгт хүчний 353 дугаар анги	46	43	3		
ДҮН		405	402	3			